

Төсөл



МОНГОЛ АРДЫН НАМ

**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДАРХАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Уриа:

**ХҮЧ НЭМЬЕ**



Бид хувь хүн, иргэн, айл өрх, албан байгууллага, баг, хамт олон, сум орон нутгийн өмнө тулгамдаад байгаа олон арван асуудлыг шийдвэрлэх үүднээсээ хүүхэд, залуус, дунд үе, ахмад настан болон нийгмийн бүхий л бүлгийн иргэд, Дарханчууд та бидэнд чиглэсэн нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хүрээнд харах алсын хараа болох мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### Нэг. Нийгмийн бодлого.

- 1.1 "Их мянган инженерчлэл" ХХК-ний хийсэн зураг төсвөөр "Bvvh" ХХК-ний гүйцэтгэж буй Сумын төсөвт байгууллагуудыг холбох Инженерийн шугам сүлжээ, нэгдсэн халаалтын ажлыг үргэлжлүүлэн айл өрх, аж ахуй нэгжүүдийг холбох, бохирын асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.2 Сумын инженерийн шугам сүлжээ, нэгдсэн халаалтыг түшиглэн Орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэн 8-н айлын орон сууц 4-ийг барина.
- 1.3 Сумын цэцэрлэгт хүрээлэнд Мод тарьж зүлэгжүүлэн, усан оргилуур барих, гэрэлт модны тоог нэмэх сүүлийн үеийн стандарт шаардалгад нийцсэн тоглоомуудыг суурилуулан хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх орчинг бүрдүүлнэ.
- 1.4 Чингис хотоос Баянмөнх сум, Дархан sumaар дайруулан Бор-өндөр сум хүртэл 195 км засмал замыг барих ажлыг эхлүүлэх
- 1.5 Улсын тусгай хамгаалалттай Дархан Хан уулын хамгаалалтын менежментийн захиргааг байгуулан аялал жуулчлалыг хөгжүүлэх, ан амьтныг хамгаалах.
- 1.6 Сумын хэмжээний түүхэн дурсгалт хөшөө, булш, бунхан, эртний хиргисүүр түүхэн газруудын тооллого явуулах, бүртгэх өрхийн тоогоор ном альбом хэвлүүлэх.



2317144297  
СЮА0046 90740

- 1.7 Сумын төвд иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, эрүүл чийрэг бие бялдартай байх, соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулаад байх боломжтой 350-400 хүний суудалтай урлаг спортын цогцолбор барих.
- 1.8 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурч, амьдрах бололцоог хангах, сумын хүн амыг нэмэгдүүлэх нэг хөшүүрэг бол суралцагч хүүхдүүдийн тоог нэмэх явдал юм. Иймд 100 хүүхдийн сурагчдын дотуур байр барих.
- 1.9 Сумын төвийн наадмын талбайг шинэчлэн, тог цахилгаанд холбох
- 1.10 Суманд малын гаралтай хоёрдагч түүхий эд болох арьс шир, ноос ноолуурын үйлдвэр шинээр байгуулах, эдийн засгийн тогтвортсуурьшилтай ажиллах, хүн амын тоог нэмэгдүүлэх, өрхийн орлого бий болгох зэрэг үндэслэлээр бодлого барьж орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан томоохон үйлдвэр барих бий болгох
- 1.11 Жишиг болон Малчдын хороолол бий болгох, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсронгуй болгож, сайжруулах
- 1.12 "ГЭРЭЛТЭЙ ГУДАМЖ, МАНАЙ ХАШАА" төсөл хэрэгжүүлж жишиг эгнээ, гудамжтай болох, хаягийг цэгцлэх
- 1.13 Төрийн байгууллагуудыг гадна талыг гоёлын гэрэлтүүлэгтэй болгох
- 1.14 Дархан сумын хүндэтгэлийн хаалга хийх
- 1.15 Хүндэтгэлийн хаалагнаа сумын төв хүртлэх замыг дагуулан мод тарих,
- 1.16 Ногоон хэрэм төгөлийг тохижуулах
- 1.17 Ус зөөдөг, бохир сордог машинтай болно.



### **Хоёр. Эрүүл мэнд боловсрол соёлын чиглэлээр**

- 2.1 Сумын эмч, сувилагч нарыг мэргэшүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах
- 2.2 Сумын эмнэлэгт хүчилтөрөгчийн аппарат болон бусад эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- 2.3 Сумын эмнэлэгт чийрэгжүүлэлтийн кабинет тохижуулах иргэд чөлөөт цагаараа ирж дасгал хийдэг хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүс нь ороод хийдэг стандартын чийрэгжүүлэлтийн кабинеттэй болно.
- 2.4 Эрүүл мэндийн төвд бүрэн тоноглолтой автомашинтай болно.
- 2.5 Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барьж дуусгана.
- 2.6 Багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэн орон сууцжуулах
- 2.7 Аймгийн хэмжээнд шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг сонгон шалгаруулж сургалтын төлбөрийг хариуцах
- 2.8 Ерөнхий боловсролын сургуулийг эко сургууль болгоно.
- 2.9 ЕБС-ийн хичээлийн байрны их засвар / Вакум цонх, шалны их засвар /
- 2.10 ЕБС-ийн Зориулалтын гал тогооны тоног төхөөрөмж
- 2.11 Цэцэрлэгийн гадна хашааны өргөтгөл
  
- 2.12 Цэцэрлэгийн хичээлийн байрны их засвар
- 2.13 Цэцэрлэгт 1 бүлэг нэмэх
- 2.14 Орон нутгийн судлах танхимын их засвар
- 2.15 Яруу найрагч Р.Чойномын гэр музейн их засвар
- 2.16 Номын сан, Бүжгийн танхимын дээврийн засвар



968

- 2.17 Сум орон нутагт ашиглагдаж байгаа гар утас, үүрэн телефоны сүлжээний өргөтгөл хийх.
- 2.18 Сургуулийн өмнөх насны хүүхэд болон сурагчдын амны хөндийг эрүүлжүүлэх, Эрүүл мэндийн төвд шүдний кабенет байгуулах
- 2.19 Суманд хүүхдийн нарийн мэргэжлийн эмчтэй болох
- 2.23 Суманд хүүхдийн нарийн мэргэжлийн эмчтэй болох

**Гурав. Хүнс, хөдөө, аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлал**

- 3.1 Хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх дэмжиж, усалгаатай тариан талбай бий болгоно.
- 3.2 Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын ажлын нөхцөлийг сайжруулах үүднээс унаа бие хамгаалах хэрэгсэл, бусад хэрэгсэлээр хангана.
- 3.3 Булаг шанд ширгэхээс хамгаалж, булгийн эхийг хаших хамгаалах ундарга гарцыг нэмэгдүүлнэ.
- 3.4 Чацарагана, царгас тарих иргэд бүлэг хоршоог дэмжинэ.
- 3.5 Сумын хур хогийг байгальд ээлтэй байдлаар цэвэрлэн хогны менежментийг хэрэгжүүлнэ.
- 3.6 Бэлчээрийг зөв зохистой ашиглах, малчдын отор хийх асуудлыг дэмжинэ.

2317144297  
СЮА0046 90740

**Дөрөв. Засаглалын бодлого**

- 4.1 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд иргэний зөвлөл байгуулна.
- 4.2 Малын хулгай, архидалтай тууштай тэмцэнэ.



### Тав. Нийгмийн хамгаалал

- 5.1 Залуучууд хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн амьдрах нөхцөлийг сайжруулах үүднээс жижиг дунд бизнесийг дэмжих чиглэлээр
- 5.5 Ахмадуудын чуулга уулзалтыг жилд 2 удаа хийж тэднийг амралт сувилалд амраана.
- 5.6 Тэмээний баяр, Түмэн адууны баяр тэмдэглэнэ.
- 5.7 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, сум орны хөгжил, иргэдийн амьдралыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэхэд хуулийн дагуу хамтарч ажиллана.
- 5.8 Сумын нутаг шинээр лицэнз олгохгүй
- 5.9 Хуримтлалын аяныг өрнүүлнэ.
- 5.10 Орон сууц худалдан авах ипотекийн зээлд хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

